

## **Монгол-Германы харилцааг чанарын шинэ шатанд гарах ирээдүй, боломж чиглэлүүд**

*Эдийн засгийн ухааны  
доктор Р. Жамиц*

Монгол-Германы найрсаг уламжлалт харилцааны сайхан ирээдүй буйг цаашид чанарын шинэ шатанд гүнзгийрүүлэн идэвхжүүлж, бүх боломжийг ашиглах нь чухал зорилт юм. Өнөө үед шилжилтийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулах, цаашдын эрчимтэй хөгжлийн үндэс суурийг тавихад ХБНГУ-тай харилцаагаа улам эрчимжүүлэх, түүний туслалцааг зохистойгоор ашиглахад олон сайхан боломж бий. Монгол орон ардчилал, зах зээлийн харилцаа хөгжүүлэх бодлогыг эргэлт буцалтгүй баримтлах болсон, улс төрийн хүчнүүд нь төлөвшиж эхэлсэн, Засгийн газар нь тогтворжиж байгаа нэг үгээр дотоод, гадаад байдал нь гадаад орны бодит тусламж авах таатай нөхцөлийг бүрэлдүүлж байгааг ашиглах нь чухал. Судлаачдын үзэж байгаагаар Монгол улс нь ойрын 10-15 жилд гадаадын зээл туслалцааг авах шаардлагатай байна. Монгол улсын хувьд эдийн засгийн эрчимтэй хөгжилд түүний бүтцийн өөрчлөлт, шинэчлэлт болон эдийн засгийн өсөлтийг цаашид дээшлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг арвижуулахад урт хугацааны хөтөлбөрийг нэн даруй боловсруулж хэрэгжүүлбэл, Германы тусламжийг үр ашигтай авч, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд чухал юм.

Ойрын ирээдүйд Монголын эдийн засгийг хөгжүүлэх, экспортын чиглэлтэй үндэсний аж үйлдвэрийг хөгжүүлэх, улсын төсвийн нөөцийг нэмэгдүүлэхэд нөлөөлөхөд Германы шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Аль ч улс, түүний дотор ХБНГУ үргэлж зээл өгч, буцалтгүй тусламж байнга үзүүлж байхгүй. Харин харилцан ашигтай төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын хувьд ч бүс нутгаа интеграцчиллын үйл явцад ч Герман улс идэвхтэй оролцох ирээдүй бий. Үүний тулд таатай нөхцлийг бүрэлдүүлж элдэв хүнд суртал, шат дамжлагуудыг өөрчлөх нь чухал. Одоогийн байдлаар Герман манайд ихээхэн туслалцаа үзүүлж, Германы зарим бизнес эрхлэгчид Монголд орж ирж байна. Гэвч эдүгээ хүртэл аль нэг нэртэй томоохон пүүсийн төлөөлөл Монголд буй болоогүй хэвээр л байна. Германы 30 орчим пүүсийн Монголд оруулсан хөрөнгийн хэмжээ одоогийн байдлаар

ганцхан сая ам доллар байгаа нь чамлалттай байна. Германы пүүсүүд Монголд гол төлөв санхүүгийн тусламжаар хийгдэж буй захиалгат үйлчилгээ, гүйцэтгэл хийж байгаа бөгөөд тухайлбал Филипп Хольцманн пүүс Монголын нийслэлийн нисэх онгоцны буудлын шинэчлэл өргөтгөлийг гүйцэтгэсэн байхад Детекон/Сименс пүүс Монголын цахилгаан холбоо, төмөр замын салбарт шинэчлэл хийжээ. Түүнчлэн цахилгаан станцуудыг засч сэлбэсэн, жижиг үйлдвэрлэлийн, тухайлбал оёдол, мах боловсруулах болон худалдааны салбарт хөрөнгө оруулсан байна.

Улсын Их Хурлаас 1996 онд батлан гаргасан “Монгол улсын үндэсний хөгжлийн үзэл баримтлал”-д Монгол улсын ойрын 15-20 жилийн гол стратеги нь нийгмийн баримжаатай, байгаль орчиндоо зохицсон, оюуны болон технологийн шинэ суурьт тулгуурласан, экспортын чиглэл бүхий, харьцангуй биеэ даасан эдийн засагтай ардчилалд үндэслэсэн улс төрийн боловсронгуй тогтолцоотой, оюуны өндөр хөгжилтэй үйлдвэржсэн орон болох явдал мөн” гэж тусгасан билээ. Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол-Германы хөгжлийн хамтын ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх, дотоод нөөц бололцоог бүрэн дайчлах нь буурай хөгжилтэй өнөө үед шилжилтийн эдийн засагтай Монгол орны хувьд амин чухал асуудал болж байна.

Хамтын ажиллагааг цаашид эрчимжүүлэхэд Монголын эдийн засгийн цаашид хөгжих ирээдүйн гол гол салбарыг зөв тодорхойлох нь чухал юм. Үүнд яваандаа нэлээд хүчээ авах магадлалтай уул уурхайн салбар чухал ач холбогдолтой байгаа. Энэ нь ялангуяа алт олборлолт, металл болон газрын тосонд хамаарна. Нөгөөтэйгүүр аж үйлдвэрийн болон үйлдвэрлэлийн бусад салбарыг боловсруулах түвшний хүчин чадлыг өсгөн нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй. Ер нь Монгол нь байгалийн баялгаар асар баян орны нэг. Монголд их байдаг зэс, алт, мөнгө, газрын ховор элементүүд, вольфрам, молибден зэрэг тээврийн зардалд онц нөлөөлөхгүй байгалийн баялагийг хамгийн орчин үеийн бөгөөд хямд өртөгтэй технологи нэвтрүүлэн олборлох шаардлагатай байна. Герман мэтийн аж үйлдвэр, ялангуяа цахилгаан техник, электроник өндөр хөгжсөн оронд Монголын дээрх байгалийн баялаг ирээдүйд зайлшгүй шаардлагатай болно.

Монголд эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэн экологийн цэвэр бөгөөд өндөр чанартай хүнсний бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, малын гаралтай арьс шир, ноос ноолуур зэрэг түүхийг

эдийг боловсруулж, сайн чанарын эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг орчин үеийн технологийг нэвтрүүлэх боломж бий.

Мөн тэрчлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх үлэмж нөөц бололцоо бий. Тэгэхдээ дэд бүтцийг хөгжүүлэх, нөхцөл бололцоог сайжруулах шаардлагатай. Хамтын ажиллагааг идэвхжүүлэхэд Монголд экспортын зориулалттай хамтарсан үйлдвэрүүдийг уул уурхай, боловсруулах бусад салбарт байгуулах нь чухал юм.

Монгол нь Азийн орон, Орос, Хятад хоёр их гүрний дунд оршдог, XXI зуунд Ази нь дэлхийн хөгжлийн гол төв болох ирээдүйтэй. Дэлхийд глобальчлал явагдаж, интеграцчилал хүчтэй болж, бүс нутгийн хамтын ажиллагаа идэвхжиж буй боломжуудыг Монгол-Германы харилцааны хөгжлийн ирээдүйд ашиглах нь чухал байна. Германы техник технологийн өнөөгийн түвшин ба ирээдүйн хөгжил нь Орос, Хятадтай Монголын зах зээл дээр өрсөлдөх бүрэн чадвартай юм. Зүүн Хойт Азийн бүс нутгийн интеграцчилал, хөгжлийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд Монгол-Герман хоёр идэвхтэй хамтран оролцох боломжтой. Энэ нь Германы Азийн чиглэлд явуулах гадаад бодлогын үзэл баримтлалын зорилгод ч нийцэх учиртай. Жишээ нь үүнд тээврийн нөхцөл, дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэх үндсэн дээр Тавантолгойн коксжих нүүрсний их нөөцийг ашиглаж Азийн орнуудад экспортлох төслүүд ч хамаарагдаж болох талтай. Ер нь Монгол нүүрсний нөөц ихтэй илэрсэн том ордууд олон бий. Герман бол дээр үеэс нүүрсийг ашиглан нефть бүтээгдэхүүн, түүнчлэн шатдаг хий хүртэл гарган ашиглаж байсан орон. Манай орны нөхцөлд хот суурин газруудад агаарын бохирдолт ихэсч байгаа нь хот суурин газруудад ялангуяа Улаанбаатарт хүмүүсийн хэт төвлөрөлт болж, хатуу түлш нь гэр хорооллын гол түлш болсонтой холбоотой. Агаарын бохирдолт аюултай байдалд хүрсэн өнөөгийн нөхцөлд гэр хорооллыг зөвхөн шатдаг хийн түлшээр хангаснаар уг түгшүүртэй байдлаас гарах боломжтой орд газрыг түшиглэн нүүрснээс шингэн хий гаргаж авах нүүрс хийн үйлдвэр байгуулах боломж байгаа билээ.

Ер нь Монгол улсын эрчимтэй хөгжилд Германы тусламжийг ашиглахдаа юуны өмнө ноу-хауг хүчтэй нэвтрүүлэх, хоёрдугаарт: санхүүгийн эх үүсвэр болон зээл, тусламжийг зохистой ашиглах, гуравдугаарт: Германы эдийн засгийн менежментийн туршлагыг сайтар ашиглах нь чухал юм. Германы хувийн компаниудын шууд хөрөнгө оруулалт түүнийг дагалдах техник, технологи, мэргэжилтэн бидэнд тус болно.

Шинэ техник, технологи, мэдээллийн технологийн хөгжлийг тэргүүлэх чиглэл болгож буй Германы туршлагыг судалж, энэ салбарт хамтран ажиллах нь чухал байна. Ер нь цаашид соёл, боловсрол, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааг улам өргөтгөж, Германд мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлыг чанарын шинэ шатанд гаргах шаардлагатай байна. Оюуны их нөөцтэй, боловсролын өндөр түвшинтэй, эдийн засаг, шинжлэх ухаан, техник өндөр хөгжсөн, угаасаа их хөдөлмөрч, хүмүүс нь бүтээх хөдөлмөрлөх онцгой чадвартай, амьдрах арга ухааныг сайн мэддэг уламжлалтай, өндөр зохион байгуулалттай, аливаа хууль дүрэм зааврыг аль ч насны хүмүүс нь чанд мөрддөг уламжлалтай, эдийн засаг, санхүүгийн асар их нөөц бүхий Герман орноос суралцах зүйл их бий.

### **Монгол улсын Цэргийн Яамнаас Герман улсын худалдааны пүүстэй холбоо тогтоох гэсэн нэгэн оролдлого**

*Г.Дашням /Ph.D ШУА-ийн  
Түүхийн хүрээлэнгийн ЭША/  
И.Будбаяр /аспирант/*

XIX зууны эцэс, XX зууны эхээр Монгол орны зах зээлд Хятад, Хаант Оросын худалдаа үйлдвэрийн капиталын зэрэгцээ Герман, Англи, Америк зэрэг тэргүүний хөгжилтэй орнуудын капитал нэвтэрч Монголын зах зээл дээр өрсөлдөх болжээ.

1921 оны 2 дугаар сард Барон Унгерний удирдсан цагаантны цэрэг монгол цэргийн тусламжтайгаар Нийслэл Хүрээг гамин цэргээс чөлөөлсний дараа өөрийн цэргийн нөөц бэлтгэлийг хангахын тулд Монгол улсын санхүүгийн чадавхийг сэргээх зорилгоор нилээд олон төрлийн арга хэмжээ авсны дотор Монгол нутагт байсан гадаадын пүүс, эд боловсруулах үйлдвэрүүдээс татвар хураах дүрмийг зохиолгон, Нийслэл Хүрээ зэрэг газрын гадаадын пүүсүүдийн тоо, орлогыг байцаалгасан. 1921 оны цагаан сард явуулсан уг тооллогын баримтаас үзвэл, 1920-1921 оны заагт Нийслэл Хүрээнд нийт 454 худалдааны пүүс ажиллаж байснаас 408-нь Хятад улсын харъяат, 37-нь Орос улсын харъяат, 9-нь бусад улсын харъяат пүүс байв. Эдгээр пүүсийн жилд гүйлгэсэн мөнгөний хэмжээ нь янчаанаар бодвол, Хятад улсын харъяат пүүснийх 6.868.220, Орос улсын харъяат пүүснийх 499000, бусад улсын пүүснийх 3.440.000 болж